



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2024 оны 12 сарын 16 өдөр

Дугаар 2/24

Баян-Овоо сум

Гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн
урамшуулал олгох тухай

Монгол Улсын Боловсролын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.3, Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.2, Монгол Улсын засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоол, Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А/430 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт, Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн "Сургуулийн өмнөх боловсролын багш, сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнг хүргүүлэх тухай" 01/260 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Багш Н.Түмэн-Өлзий, Д.Бямбатогоо, нарт дөрөвдүгээр улирлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн урамшууллыг олгосугай.
2. Багш Н.Түмэн-Өлзий, Д.Бямбатогоо нарт 10,11,12 дугаар сар бүрийн 15%-иар албан тушаалын сарын үндсэн цалингаас тус тус тооцож хууль журмын дагуу олгохыг нягтлан бодогч (Г.Баасансүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЭРХЛЭГЧ



Ц.ЭНХМАА